



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Музейн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2023/42/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Улаанбаатар хот
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Д.Эрдэнэтуяа
Утас: 99569599

Цахим хаяг: www.open.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

ДдЗ. 03.13 № 285
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН МУЗЕЙН ЗАХИРАЛ
Н.НЯМСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант хугацаанд 1,998.17 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг тушаалын дагуу бодоогүй, үр чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй олгосон, 5,443.53 мянган төгрөгийг батлагдсан орон тооны хязгаараас хэтрүүлэн ажил хавсарсны нэмэгдэл цалин олгосон, 335.86 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл, хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн ба зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар бараа материал 15,655.01 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 4,583,554.03 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 4,605,577.53 мянган төгрөг байна. Тайлант онд улсын төсвөөс 251,228.70 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 183,190.90 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанд 393,907.87 мянган төгрөгийг зарцуулж, 40,511.72 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлогоос 8,404.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 675.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, харилцах дансанд 6,368.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

232330367

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 7,777.57 мянган төгрөгийн зөрчил илэрч 5,443.53 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2,334.03 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, анхан шатны баримтын бүрдлийг хангах, нягтлан бодох бүртгэлийг зохих заавар журмын дагуу үнэн зөв хөтлөн, бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,637,095.00</u>	<u>22,023,505.99</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	608,304.00	6,368,486.99
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	608,304.00	6,368,486.99
3121	Төгрөг	608,304.00	6,368,486.99
31211	Төрийн сангийн харилцах	-	6,365,182.99
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	608,304.00	3,304.00
33	АВЛАГА	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	25,028,791.00	15,655,019.00
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	25,028,791.00	15,655,019.00
35410	Бичиг хэргийн материал	1,094,400.00	-
35420	Аж ахуйн материал	21,704,391.00	11,982,119.00
35450	Барилгын засварын материал	2,230,000.00	3,672,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,437,966,538.09</u>	<u>4,583,554,032.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,437,966,538.09	4,583,554,032.38
392	Биет хөрөнгө	4,260,229,038.09	4,405,816,532.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,344,695,348.27	3,344,695,348.27
39202	Хуримтлагдсан элэгдэл	(68,950,352.24)	(150,184,212.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,000,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,600,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	34,708,852.00	265,642,704.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,687,122.67)	(30,744,710.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,285,468.00	20,629,058.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,722,404.27)	(15,679,237.19)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	965,561,480.00	965,561,480.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	937,769.00	5,937,769.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(41,666.67)
393	Биет бус хөрөнгө	177,737,500.00	177,737,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	177,737,500.00	177,737,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,463,603,633.09</u>	<u>4,605,577,538.37</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,142,606.11</u>	<u>3,100,320.59</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,142,606.11	3,100,320.59
413	Өглөг	1,142,606.11	3,100,320.59
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,142,606.11	3,100,320.59
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,462,461,026.98</u>	<u>4,602,477,217.78</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,462,461,026.98	4,602,477,217.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	279,495,619.00	279,495,619.00
51101	Өмч: - төрийн	279,495,619.00	279,495,619.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,422,702,213.55	3,562,718,404.35
51210	Өмнөх үеийн үр дүн	3,422,702,213.55	3,422,702,213.55
51220	Тайлант үеийн үр дүн	-	140,016,190.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	760,263,194.43	760,263,194.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,463,603,633.09</u>	<u>4,605,577,538.37</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,421,581,519.00	682,418,510.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,214,726,019.00	247,998,910.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,214,726,019.00	247,998,910.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,214,726,019.00	247,998,910.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	675,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,377,300.00	8,404,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,213,348,719.00	238,919,910.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	206,855,500.00	434,419,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	197,627,500.00	251,228,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	197,627,500.00	251,228,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,228,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,108,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,880,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	240,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	183,190,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	183,190,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	222,904,396.03	539,702,319.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	222,904,396.03	539,702,319.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	219,059,004.18	487,869,895.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,192,640.68	230,998,734.60
210101	Үндсэн цалин	100,680,528.42	188,532,665.56
210102	Нэмэгдэл	29,554,363.26	29,913,450.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,957,749.00	9,057,633.25
210104	Урамшуулал	-	3,494,985.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,527,783.80	28,670,892.63
210201	Тэтгэврийн даатгал	12,635,411.89	19,509,322.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,473,093.01	2,290,370.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,178,474.44	1,832,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	294,618.57	458,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,946,185.89	4,580,999.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,211,029.14	96,263,090.09
210301	Гэрэл, цахилгаан	1,564,219.14	7,117,995.09
210302	Түлш, халаалт	16,284,220.00	86,039,795.00
210303	Цэвэр, бохир ус	362,590.00	3,105,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,078,740.00	32,428,262.00
210401	Бичиг хэрэг	3,456,260.00	11,312,870.00
210402	Тээвэр, шатахуун	2,372,400.00	2,437,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,752,880.00	1,611,540.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	353,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,143,700.00	17,066,452.00
2105	Нормативт зардал	210,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	210,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,043,287.00	900,500.00
210602	Тавилга	8,288.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	110,000.00	-
210604	Урсгал засвар	4,924,999.00	900,500.00
2107	Томилот, зочны зардал	1,881,000.00	1,050,000.00

210702	Дотоод албан томилолт	1,881,000.00	1,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	1,926,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,926,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,590,523.56	95,632,415.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,777,300.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,813,223.56	95,632,415.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,845,391.85	51,832,424.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,168,996.00	11,320,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	9,197,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,168,996.00	2,123,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,676,395.85	40,511,724.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,676,395.85	40,511,724.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,198,677,122.97	142,716,190.80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,700,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	2,700,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,700,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,198,677,122.97	140,016,190.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	208,232,800.00	443,498,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,377,300.00	9,079,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,377,300.00	9,079,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,377,300.00	9,079,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	675,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,377,300.00	8,404,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	206,855,500.00	434,419,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	197,627,500.00	251,228,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	197,627,500.00	251,228,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,228,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,108,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,880,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	240,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	183,190,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	183,190,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	200,767,196.00	437,738,417.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	200,767,196.00	437,738,417.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	196,921,804.15	385,905,992.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,845,835.02	229,082,112.75
210101	Үндсэн цалин	99,333,722.76	174,272,426.61
210102	Нэмэгдэл	29,554,363.26	33,143,665.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,957,749.00	10,589,537.99
210104	Урамшуулал	-	11,076,482.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,382,830.99	28,629,800.00
210201	Тэтгэврийн даатгал	12,990,769.59	19,468,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,348,015.35	2,290,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,078,772.30	1,832,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	269,243.03	458,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,696,030.72	4,581,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,211,029.14	96,263,090.09
210301	Гэрэл, цахилгаан	1,564,219.14	7,117,995.09
210302	Түлш, халаалт	16,284,220.00	86,039,795.00
210303	Цэвэр, бохир ус	362,590.00	3,105,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,291,110.00	6,698,390.00
210401	Бичиг хэрэг	3,612,900.00	932,170.00
210402	Тээвэр, шатахуун	2,372,400.00	2,694,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,742,280.00	1,624,020.00
210404	Ном, хэвлэл	37,330.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	393,500.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,132,700.00	1,287,400.00

2105	Нормативт зардал	210,000.00	322,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	210,000.00	322,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,375,999.00	8,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	7,125,999.00	6,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,881,000.00	1,050,000.00
210702	Дотоод албан томилолт	1,881,000.00	1,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	10,860,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,860,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	5,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,845,391.85	51,832,424.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,168,996.00	11,320,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	9,197,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,168,996.00	2,123,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,676,395.85	40,511,724.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,676,395.85	40,511,724.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,465,604.00</u>	<u>5,760,182.99</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,480,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,480,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,480,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	5,480,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,480,000.00)</u>	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,985,604.00	5,760,182.99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		608,334.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	608,334.00	6,368,486.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн				
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,495,619.00	760,263,194.43	3,422,702,213.55	4,462,461,026.98
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	279,495,619.00	760,263,194.43	3,422,702,213.55	4,462,461,026.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	140,016,190.80	140,016,190.80
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,495,619.00	760,263,194.43	3,562,718,404.35	4,602,477,217.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,504,700.00	396,621,692.84	44,883,007.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,504,700.00	396,621,692.84	44,883,007.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430,731,500.00	385,905,992.84	44,825,507.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,140,300.00	229,082,112.75	58,187.25
210101	Үндсэн цалин	103,922,600.00	174,272,426.61	(70,349,826.61)
210102	Нэмэгдэл	105,065,300.00	33,143,665.40	71,921,634.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,072,000.00	10,589,537.99	(1,517,537.99)
210104	Урамшуулал	11,080,400.00	11,076,482.75	3,917.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,629,800.00	28,629,800.00	-
210201	Тэтгэврийн даатгал	19,468,300.00	19,468,300.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,290,300.00	2,290,300.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,832,100.00	1,832,100.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	458,100.00	458,100.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	4,581,000.00	4,581,000.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,672,900.00	96,263,090.09	40,409,809.91
210301	Гэрэл, цахилгаан	8,481,000.00	7,117,995.09	1,363,004.91
210302	Түлш, халаалт	124,271,900.00	86,039,795.00	38,232,105.00
210303	Цэвэр, бохир ус	3,920,000.00	3,105,300.00	814,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,745,900.00	6,698,390.00	(952,490.00)
210401	Бичиг хэрэг	867,500.00	932,170.00	(64,670.00)
210402	Тээвэр, шатахуун	2,144,400.00	2,694,800.00	(550,400.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,624,020.00	(124,020.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	160,000.00	(60,000.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,134,000.00	1,287,400.00	(153,400.00)
2105	Нормативт зардал	322,600.00	322,600.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	322,600.00	322,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	1,500,000.00	-
210604	Урсгал засвар	6,500,000.00	6,500,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	360,000.00	1,050,000.00	(690,000.00)
210702	Дотоод албан томилолт	360,000.00	1,050,000.00	(690,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,860,000.00	10,860,000.00	1,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,860,000.00	10,860,000.00	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	5,000,000.00	5,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	5,000,000.00	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,773,200.00	10,715,700.00	57,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,773,200.00	10,715,700.00	57,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,197,700.00	9,197,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,575,500.00	1,518,000.00	57,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441,504,700.00	402,986,875.83	(38,517,824.17)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	251,241,300.00	251,228,700.00	12,600.00

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг тушаалын дагуу олгоогүй	1	1,998.17	1	1,998.17								
Анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан	1	335.86	1	335.86								
Ажил хавсарсны нэмэгдэл илүү олгосон	1	5,443.53			1	5,443.53						
Дүн	3	7,777.57	2	2,334.03	1	5,443.53						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		